



MNS ISO/IEC 17020:2013 стандартад итгэмжлэгдсэн байгууллага
РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВ



УЛААНБААТАР ХОТЫН РӨН-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД 2026 ОНЫ 02 ДУГААР САРД ХИЙСЭН СУУРИН ХЯНАЛТЫН МЭДЭЭ

Тайлангийн дугаар: Хяналт/2026/06

Хэвлэсэн огноо: 2026.03.16

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын FM радио станцад MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг мөрдүүлэх.

2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2026.02.02	Улаанбаатар хотын СХД-ийн 34-р хороонд байрлах ХХЗХ-ны РДӨНХТ	/47°54'51.50"N 106°45'43.33"E/
2	2026.02.28	Улаанбаатар хотын СБД-ийн 06-р хороонд байрлах ХХЗХ-ны төв оффис	/47°55'38"N 106°54'52"E/



Зураг 1. Хэмжилт хийсэн FMS-2020 суурин хяналтын станцын байршил.



Зураг 2. Хэмжилт хийсэн FMS-2014 суурин хяналтын станцын байршил.

3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

FMS-2020 суурин хяналтын станц /RmcFX2dm02Mn/.

FMS-2014 суурин хяналтын станц /CN011623/.


4. Норматив бичиг баримт:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандарт.


5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:

Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	Ц.Өсөхбаяр	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын ахлах инженер
2	Ж.Дөлгөөн	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер
3	М.Чагнаадорж	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер

6. Хэмжилт хийх үеийн зураг:



Зураг 3. Радио давтамжийн 88-108 МГц-ийн зурваст ажиллаж буй FM радио станцууд.



Зураг 4. FM радио станцын дохионы параметруудийн хэмжилт.

7. Хэмжилтийн дүн:

Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв нь радио давтамжийн суурин хяналтыг тогтмол хийдэг. Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 33 үйлчилгээ эрхлэгчийн FM радио станцад 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 28-ны өдрүүдэд суурин хяналтыг хийж гүйцэтгэлээ.


MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын 5 дугаар зүйлд заасан давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц, нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц, хэрэглэх зурвасын өргөн 300 кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг 29 FM радио станц хангаж үйл ажиллагаа явуулж байгаа нь хэмжилтээр тогтоогдсон.

7.1 Стандартын шаардлагыг хангасан үйлчилгээ эрхлэгчид:

MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангасан үйлчилгээ эрхлэгчдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1.	Эм Жи Эл Радио ньюс ХХК	22800192	88.3
2.	СКОД ХХК	22800167	88.8
3.	Сета тех ХХК	22800193	89.3
4.	Эх болсон зургаан зүйл НҮТББ	22800186	89.7
5.	Манай аялгуу эф эм ар ХХК	22800178	90.5
6.	Монгол комикс ХХК	22800159	91.1
7.	Хэмнэлт долгион медиа групп ХХК	22800147	91.7
8.	Смарт коммуникэйшн ХХК	22800158	92.1
9.	Тэргүүн медиа ХХК	22800146	92.5
10.	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол сан ТББ	22800097	95.7
11.	Авторадио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	96.3
12.	Эх элгэн нутаг ХХК	22800114	96.9
13.	Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд ШБ	22800071	97.5
14.	Радиоком Монгол ХХК	22800025	98.1
15.	Монголиан Мюзик Медиа ХХК	22800024	98.9
16.	Нью медиа ХХК	22800026	99.3
17.	Дижитал радио ХХК	22800060	99.7
18.	РТҮС УТҮГ	22800044	100.9
19.	Агрегатор ХХК	22800022	101.7
20.	Эм Эс Жи Эм Эл ХХК	22800175	102.1
21.	Бадруун ХХК	22800006	102.5
22.	РТҮС УТҮГ	22800044	103.1
23.	Медиа холдинг ХХК	22800009	103.6
24.	Ви Өү Эм ХХК	22800052	104.0
25.	Салхи Энтертейнмент ХХК	22800057	104.5
26.	Чугу ХХК	22800037	105.5
27.	РТҮС УТҮГ	22800044	106.0

28.	И Зэт Эф Эм ХХК	22800038	107.0
29.	Билэг санаа ХХК	22800018	107.5




Зураг 5. Хэрэглэх зурвасын өргөний хэмжилтийн дүн.

7.2 Стандартын шаардлагыг хангаагүй үйлчилгээ эрхлэгчид:

MNS 4909:2000 стандартын 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй буюу давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц -ээс хэтэрсэн үйлчилгээ эрхлэгчдийн мэдээлэл:


№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1.	Шүхэр ТББ	22800117	95.1
2.	НС Холбоо ХХК	22800040	100.5



Зураг 6. Давтамжийн хазайлтын хэмжилтийн дүн.

MNS 4909:2000 стандартын 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй буюу зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц -ээс хэтэрсэн үйлчилгээ эрхлэгчийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1.	НС Холбоо ХХК	22800040	100.5



Зураг 7. Зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлтын хэмжилтийн дүн.


MNS 4909:2000 стандартын 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй буюу давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц -ээс хэтэрсэн, зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц -ээс хэтэрсэн НС Холбоо ХХК-д стандартын шаардлагыг хангуулахаар тус хорооноос 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05/488 дугаартай албан бичгийг, давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц -ээс хэтэрсэн Шүхэр ТББ-д стандартын шаардлагыг хангуулахаар 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05/489 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн.

7.3 Үйл ажиллагаагаа түр зогсоосон үйлчилгээ эрхлэгчид:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1.	РФ ХХК	22800005	100.1
2.	Стандарт Ви Оү Эй ХХК	22800001	106.6


Үйл ажиллагаагаа түр хугацаанд зогсоосон 100.1 МГц-ийн FM радио станцын үйлчилгээ эрхлэгч болох РФ ХХК-д тус хорооноос үйл ажиллагаагаа явуулахгүй байгаа тайлбар, мэдээллийг авахаар 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 05/500 дугаартай албан бичгийг хүргүүллээ.

7.4 FM радиогийн дахин дамжуулах станцууд:



Зураг 8. Радио давтамжийн 76-87.5 МГц-ийн зурваст ажиллаж буй FM радиогийн дахин дамжуулах станцууд.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2026 оны 02 дугаар сарын байдлаар үйл ажиллагаагаа явуулж буй хэт богино долгионы FM радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцуудын мэдээлэл:



Зураг 9. Үйл ажиллагаагаа явуулж буй FM радиогийн дахин дамжуулах станцууд.

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1.	РТҮС УТҮГ	22830021	76.1
2.	Эм Жи Эл Радио ньюс ХХК	22830001	76.5 ¹
3.	Чугу ХХК	22830003	76.9
4.	Сета тех ХХК	22830002	77.3
5.	Манай аялгуу эф эм ар ХХК	22830004	77.7
6.	Эх элгэн нутаг ХХК	22830005	78.1
7.	СКОД ХХК	22830018	79.3
8.	Бадруун ХХК	22830009	80.5
9.	Эм Эс Жи Эл ХХК	22830012	82.1
10.	РТҮС УТҮГ	22830019	82.9
11.	И Зэт Эф Эл ХХК	22830008	83.3
12.	Дижитал радио ХХК	22830017	83.7
13.	Радиоком Монгол ХХК	22830020	84.1
14.	Салхи Энтертейнмент ХХК	22830015	84.5

8. Дүгнэлт:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хэт богино долгионы FM радио станцуудын 87.8% нь MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг ханган ажиллаж байна. Цаашид FM радиогийн үйлчилгээ эрхлэгчид хүлээн авах талд хэмжигдэж буй радио долгионы параметруудыг стандарт хэмжээнд байлгах,

¹ Эм Жи Эл Радио ньюс ХХК-ийн 22830001 дугаартай радио давтамжийн тусгай зөвшөөрөлтэй 76.5 МГц-ийн FM радиогийн дахин дамжуулах станц нь 2026 оны 02-р сарын 02-ны өдрөөс 02-р сарын 26-ны өдрүүдэд түр хугацаанд ажиллаагүй.

сонсогчдод сонсогдож буй дууны сонсголын чанарыг сайжруулахын тулд нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд буюу антен, нэвтрүүлэгч, чадлын өсгөгч, холболтын кабель (фидер кабель, аудио кабель)-д техникийн хяналт, үзлэг, үйлчилгээг тогтмол хийж байх, мөн студийн дууны холигч пультны түвшинг үргэлжлүүлэн хянаж байхыг зөвлөж байна.